



ҮНДЭСНИЙ АУДИТЫН
ГАЗРЫН ХАРЬАА
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайсөр, Өвөрхангай аймаг,
Улаанбаатар, (976) 7032-3253,
E-mail: ovorkhangai@audit.gov.mn

2015. 08. 06 № 83
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болгосон, акрузал сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д заасан бүрэн эрхийн дагуу Аймгийн Аудитын газраас аудит хийв.

Төсвийн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Төсвийн захирагчийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Төсвийн захирагчийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйцээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтөлвөл, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйцээгүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.РЭНЦЭНХАНД



АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

ТАБ-ын Тэргүүлэх аудитор
Д.Рэнцэнханд
Утас: 70323253
Цахим хаяг:

Аудитын менежер: Ц.Отгонням
Утас: 88946933
Цахим хаяг:

Аудитор: Б.Эрдэнэцэцэг
Утас: 99017254
Цахим хаяг:

ТАБ-ын хаяг: НЗОрдон
Байршил 4 давхар 402 тоот
Цахим хуудас:

2015 оны 03 дугаар сар

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ААГ-10/2015/12-СТА / аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн төсвийн 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Нийгмийн даатгалын хэлтсийн 2014 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2014 оны 03 дугаар сарын 02-ноос 2015 оны 03 дугаар сарын 06-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитын багийн гишүүн аудитор Б.Эрдэнэцэцэг, шинжээч Н.Буянтогтох нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төсвийн захирагчийн 2014 оны төсвийн санхүүгийн тайланг 2015 оны 03 дугаар сарын 02-нд ТАБ-т ирүүлсэн байна.

ТАБ аудитыг 2015 оны 03 дугаар сарын 02-ноос 2015 оны 03 дугаар сарын 05-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2015 оны 03 дугаар сарын 06-нд НДХХэлтсийн байгууллагын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол улсын Нийгмийн даатгалын тухай багц хууль, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, ТБОНӨХБАУХА тухай, ХХСОАТ-ын тухай хуулиуд болон холбогдох ЗГ-ын тогтоол, сайдын тушаал болонУНДЕГ-ын даргын тушаалаар баталгаажсан журмуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн хуулийн хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.2-т "Нийгмийн даатгалын байгууллага" гэж ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэл болон хуульд заасан бусад эх үүсвэрээр нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг бүрдүүлж, даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох үйл ажиллагааг эрхэлж байгаа хуулийн этгээдийг; 2.1.3-т "Нийгмийн даатгалын сан" гэж ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг; хэлнэ гэж тодорхойлсон

Тус байгууллага 2014 онд "Нийгмийн даатгалын ажилчдын хөгжлийг дэмжих" зорилт тавин ажиллаж байна. Тухайн байгууллагын удирдлага нь Нийгмийн даатгалын тухай хуулийн

22.1-т Нийгмийн даатгалын төв байгууллага нь нийгмийн даатгалын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний, орон нутгийн байгууллага нь тухайн шатны Засаг дарга болон нийгмийн даатгалын дээд шатны байгууллагын удирдлагын дор ажиллана.

22.4-т Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газар, хэлтсийн даргыг нийгмийн даатгалын байгууллагад 3-аас доошгүй жил ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилно." Гэж зөвсн дагуу томилогджээ.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой хуулиуд хэрэгжиж иржээ.

Харин Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9.1-д "Аж ахуй нэгж, байгууллага нь хөрөнгө, ор төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана." гэсэн заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар", Сангийн сайдын 2013 оны 269 дүгээр тушаалын холбогдох заалтуудын хэрэгжилт хангалтгүй байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд,УСНБӨУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төсвийн захирагчийн төсвийн 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай үлэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжуулав. (ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар 9 хяналтын горимоор 44 нарийвчилсан сорилыг гүйцэтгэв. (ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНБӨУС-тай нийцсэн байна.ОУ-ын стандартаар нийцсэн бүртгэлийн бодлоготой, бүртгэлийн программ уялдан байна.

Төсвийн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуула явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. (ТАБ-СТА-В-2/

Төсвийн захирагчийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу тухайн байгууллагын Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Нийгмийн Даатгалын санд 2014 оны Сангийн орлого зарлагын тайлангаар 25544702.0 мянган төгрөгийн орлого төвлөрч 42479438,3 мянган төгрөгийн зарцуулалт хийгдсэн байна. Мөнгөн гүйлгээний тайлангаар оны эхэнд 581888,5 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэлтэй байсан ба 68029556,3 мянган төгрөгийн орлого орж, 67278502,9 мянган төгрөгийн зарцуулалт хийгдэж 1332942,0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ.

Нийгмийн даатгалын хэлтэс нь 2014 оны үйл ажиллагаанд Улсын төсвөөс урсгал санхүүжилтээр 533507,8 мянга, нэмэлт санхүүжилтээр 11600,0 мянга, үйл ажиллагааны орлогоор 1214,8 мянга, үнэ төлбөргүй хөрөнгийн орлого 18273,0 мянга, бүгд 564595,6 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, үйл ажиллагааны зардалд 582463,7 мянган төгрөгийг зарцуулж, хөрөнгө, бараа материал худалдсаны гарзавар 1319,4 мянган төгрөгийг бүртгэж (19187,5) мянган төгрөгийн сөрөг үр дүнтэй гарчээ.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын нийлмэл эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын 17, нарийвчилсан 27, нийт 44 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Эдгээр эрсдлүүд нь хөрөнгийн хадгалалт хангаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэж хэрэглэгчдийг буруу мэдээллээр хангах, үүнээс шалтгаалж байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулах, зарим хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй юм.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Төсвийн захирагчийн төсвийн 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний томоохон дүнтэй зардлууд, ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалав. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний 1 алдаа илэрсэн байна. Үүнд:

1. НДХэлтсийн 2014 оны үйл ажиллагааны санхүүгийн тайланд аудит хийхэд НББ-ийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д " Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана." гэсэн заалтыг зөрчин 500,0 мянган төгрөгөөр хийгдсэн веб сайтыг үндсэн хөрөнгөнд тусгалгүй шууд зардалд бичсэн байна.

Шийдвэрлэсэн: 2015 оны эхний хагас жилийн тайланд Үндсэн хөрөнгийн биет бус хөрөнгийн ангилалд бүртгэх тухай албан шаардлага өгөгдөв.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. НДЕГ-аас ирсэн 16253,0 мянган төгрөгийн хөрөнгийн орлого, мөн дээд байгууллагаас үнэ төлбөргүй ирсэн бараа материалыг Үр дүнгийн тайланд буруу дансаар бүртгэж тайлагансан байгаа нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хэвсрэлтээр батлагдсан дансны заавар болон Сангийн сайдын 2013 оны 269 дүгээр тушаалын заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Тайланд залруулсан ба зөрчлийг дахин давтахгүй байх талаар зөвлөмж өгсөн.

2. Урсгал засварын зардалд зарцуулсан 510,0 мянган төгрөг, түлш халаалтын зардлын 7304,0 мянга, бүгд 7814,0 мянган төгрөгийн материалын тайлангаар дамжуулалгүй шууд зардалд бичсэн байгаа нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хэвсрэлтээр батлагдсан дансны зааварыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Цаашид материаллаг шинжтэй зардлуудыг материалын тайлангаар дамжуулж бүртгэж байх тухай зөвлөмж өгсөн.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулах материаллаг бус алдаа тогтоогдоогүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахаар он дамжин хэрэгжих төсөл хөтөлбөр болон, хөрөнгө оруулалтын эжил байхгүй болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч, дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар үйл ажиллагаатай холбоотой нийт 26587,0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч үүнээс 500,0 мянган төгрөгийн зөрчлөд албан шаардлага өгч, 18273,0 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 7814,0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өгөгдсөн болно.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн төсвийн 2013 оны санхүүгийн тайланд Аймгийн аудитын газраас хийсэн аудитаар 3 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлсэн талаар биелэлтийг гарган ирүүлсэн байна.

Зөвлөмж:

1. Албан шаардлагын биелэлтийг заасан хугацаанд гаргаж ирүүлэх.
2. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хэвсрэлт, 2013 оны 269 дүгээр тушаалуудын дагуу үнэн зөв тайлагнах.
3. Цаашид материаллаг шинжтэй зардлуудыг материалын тайлангаар дамжуулан бүртгэж тайлагнах.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн дүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 2 хуудас, хавсралтууд 10 хуудсыг тус тус хавсаргав.

	АУДИТЫН ТАЙЛАНГ	
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:	ХЯНАСАГ 	Д.РЭНЦЭНХАНД
АУДИТЫН МЕНЕЖЕР:	БЭЛТГЭСЭН 	Ц.ОТГОННЯМ
АУДИТОР:		Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ

2015 ОНЫ 03 ДУГААР САРЫН 06

Менежментийн захидал

Аймгийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн шууд захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлангал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Төсвийн захирагчийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Биет бус хөрөнгийг бүртгэх

Тэргүүлэх ач
холбогдол №1

ААГ-ын ажиглалт

Арвайн дел ХХК-иар гүйцэтгүүлсэн 500,0 мянган төгрөгийн веб сайтыг хөрөнгөнд орлогод авалгүй шууд зардал болгосон байгаа нь НББ-ийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д " Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана." гэсэн заалтыг зөрчсөн байна.

ААГ-ын зөвлөмж

1.Хөрөнгийг орлого авч албан шаврдлагын биелэлтийг заасан хугацаанд гаргаж ирүүлэх.

Эрсдэлүүд

Хөрөнгийн хадгалалт хамгаалалтын байдалд эрсдэлтэй

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн, болно.

ААГ-ын ажиглалт

НДЕГ-аас ирсэн 16253,0 мянган төгрөгийн үнэтэй үндсэн хөрөнгө, 2020,0 мянган төгрөгийн бараа материалын орлогыг туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн байгаа нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал, 2013 оны 269 дүгээр тушаалуудын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Тайлангийн илэрхийлэгдэх мэдээллээс хангана.	үзүүлэлтүүд хэрэглэгчдийг	буруу буруу
--	------------------------------	----------------

ААГ-ын зөвлөмж

1. Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хэвсрэлтээр батлагдсан дансны зааврыг мөрдөж ажиллах.
2. Сангийн сайдын 2013 оны 269 дүгээр тушаалыг мөрдөж ажиллах.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутааглыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн

ААГ-ын ажиглалт

510,0 мянган төгрөгийн урсгал засварын зардал, 7304 мянган төгрөгийн нүүрсний НББ-ийн журналын бичилтийг буруу хийж шууд зардалд бичсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар НББ-ийн дансны зааврыг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Журмын хэрэгжилт хангагдахгүй.

ААГ-ын зөвлөмж

1. НББ-ын журналын бичилтээ зөв хийж, материаллаг шинжтэй зардлуудаа тооцсоны дансаар дамжуулж дансны давхар бичилт хийж, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан НББ-ийн дансны зааврыг мөрдөж ажиллах.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутааглыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

АУДИТОР:



Д.РЭНЦЭНХАНД

Ц.ОТГОННЯМ

Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ

2015 ОНЫ 03 ДУГААР САРЫН 06



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2015 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 82/82

Араажхор

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА
С.ЛУВСАНСАМБУУ-Д

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд 500,0 мянган төгрөгийн веб сайтыг үндсэн хөрөнгөнд орлого авч үлдэгдлээр бүртгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9.1-д "Аж ахуй нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана." гэсэн заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хэвсрэлтын "Төсвийн байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх" журамны 4.78-д "Нэгээс дээш жилийн тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж буй хөрөнгийг үндсэн хөрөнгө гэнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дахь "Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх" гэсэн заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.1-д "алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд акт, албан шаардлага өгнө" гэсэн заалтуудыг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

Дээрх 500,0 мянган төгрөгийн веб сайтыг үндсэн хөрөнгийн биет бус хөрөнгөнд бүртгэн хариуг 2015 оны 07 дугаар сарын 01-ний дотор Аймгийн Аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Нийгмийн даатгалын хэлтсийн дарга С.Лувсансамбуу, нягтлан бодогч Ц.Лхамсүрэн нараас шаардаж байна.

Шаардлагыг хэрэгжүүлээгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь заалтыг үндэслэн хариуцлага тооцохыг анхааруулж байна.

АХЛАХ АУДИТОР Д.ГАНСУХ
АУДИТОР Б.ӨРДЭНЭЦЭЦЭГ
ШИНЖЭЭЧ Н.БУЯНТОГТОХ





АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН 2014 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Биет бус хөрөнгө.....2

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1

Үнэ төлбөргүй орлого..... 2

Тэргүүлэх ач холбогдол №3 зүйлс:

Асуудал 1

Зардлын бүртгэл..... 3

2015 оны 03 дугаар сарын 06

Үр дүнгийн тайлан мөнгөн гүйлгээний тайлангийн уялдааг шалгах хүснэгт

НДСангийн

2014 он

Үзүүлэлт	Үр дүнгийн тайлан	Мөнгөн гүйлгээний тайлан	Зөрүү	Үр дүнгийн тайлан	Мөнгөн гүйлгээний тайлан	Зөрүү
Санхүүгийн тайлангаар				Аудитаар		
Үндсэн үйл ажиллагааны орлогын дүн	25544702.0	68029556.3		25544702.0	68029556.1	
Авлагын нэмэгдсэн өөрчлөлт хасах	6803.3			6803.3		
Авлагын буурсан өөрчлөлт нэмэх						
Нийгмийн даатгалын төв сэнгаас авсан санхүүжилт нэмэх	27949000.0			27949000.0		
Улсын төсвөөс авах тэтгэврийн авлага хасах	9203871.2			9203871.2		
Орлогын дүн	44283027.5	68029556.3		44283027.5	68029556.1	
Үндсэн үйл ажиллагааны зардлын дүн	42479438.3	67278502.9		42479438.3	67278502.9	
Өглөгийн нэмэгдсэн өөрчлөлт хасах				0		
Өглөгийн буурсан өөрчлөлт нэмэх	20794.3			20794.3		
Нийгмийн даатгалын төв санд төвлөрүүлсэн мөнгө нэмэх	1051833.0			1051833.0		
Урьд онд илүү олгож дахин авлага үүсгэж бичсэн тэтгэвэр тэтгэмжийн авлага хасах	13993.5			13993.5		
Оршуулгын тэтгэмжийн зөрүү нөхөн олгосон нэмэх	0.0			0.0		
Ажилгүйдлийн тэтгэмжээ авч дуусгалгүй ажилд орсон хүний тэтгэмжийн авлага хасах	6098.0			6098.0		
Зарлагын дүн	43531974.1	67278502.9		43531974.1	67278502.9	
Мөнгөн хөрөнгийн өөрчлөлт	751053.4	751053.4	0.0	751053.4	751053.2	0.2

Баталгаажуулсан: Аудитор  Б.Зоднаццэг



Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын сан

Үлдэгдлийн тэнцэл /милан төгрөгөөр/ 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

	Аудитлагдаагүй дүн	Аудитлагдсан дүн	Өөрчлөлт
ХӨРӨНГӨ			
БЭЛЭНМӨНГӨ	-	-	-
ХАРИЛЦАХ БА БУСАД МӨНГӨ	1,332,942.0	1,332,942.0	-
Харилцах	1,332,942.0	1,332,942.0	-
АВЛАГА	38,611.0	38,611.0	-
НДШ-ийн авлага	6,237.7	6,237.7	-
Улсын төсвийн санхүүжилтийн авлага	18,268.4	18,268.4	-
Бусад авлага	14,104.9	14,104.9	-
УРЬДЧИЛГАА	8,326.50	8,326.50	-
Эмнэлгүүдэд олгосон урьдчилгаа	8,326.50	8,326.50	-
ХӨРӨНГИЙН ДҮН	1,379,879.50	1,379,879.50	-
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,379,879.50	1,379,879.50	-
ӨР ТӨЛБӨР			
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	206,714.3	206,714.3	-
Тэтгээр, тэтгэмжийн төлбөрийн өглөг	25,601.4	25,601.4	-
Урьдчилж төлсөн шимтгэлийн орлого	175,108.0	175,108.0	-
бусад өглөг	6,004.9	6,004.9	-
УРТ ХУГАЦААТ ӨРТӨЛБӨР	-	-	-
САН БА ӨМЧ	1,173,165.2	1,173,165.2	-
Тэтгээрийн даатгалын сан	1,271,157.7	1,271,157.7	-
Тэтгэмжийн даатгалын сан	62,899.7	62,899.7	-
ҮОМШӨ-ний даатгалын сан	368,824.6	368,824.6	-
Зрүүл мэндийн даатгалын сан	275,337.3	275,337.3	-
Ажилгүйдлийн даатгалын сан	128,580.10	128,580.10	-
ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	206,714.3	206,714.3	-
ӨР ТӨЛБӨР БА НИЙТ ХУРИМТЛАГДСАН ҮР ДҮН	1,379,879.50	1,379,879.50	-

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО ЗАРЛАГЫН ТАЙЛАН

2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар /милан төгрөгөөр/

	Аудитлагдаагүй дүн	Аудитлагдсан дүн	Өөрчлөлт
ОРЛОГО			
САНГИЙН ОРЛОГО	25,544,702.0	25,544,702.0	-
Тэтгээрийн даатгалын сангийн орлого	19,776,102.2	19,776,102.2	-
Тэтгэмжийн даатгалын сангийн орлого	1,147,349.9	1,147,349.9	-
ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого	947,384.2	947,384.2	-
Зрүүл мэндийн даатгалын сангийн орлого	3,428,589.1	3,428,589.1	-
Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого	245,276.6	245,276.6	-
ЗАРЛАГА			
САНГИЙН ЗАРЛАГА	42,479,438.3	42,479,438.3	-
Тэтгээрийн даатгалын сангийн зарлага	34,600,358.0	34,600,358.0	-
Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага	1,458,935.0	1,458,935.0	-
ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага	204,851.6	204,851.6	-
Зрүүл мэндийн даатгалын сангийн зарлага	6,086,133.2	6,086,133.2	-
Ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага	129,160.5	129,160.5	-
ОРЛОГО ЗАРЛАГЫН ЗӨРҮҮ	- 16,934,736.3	- 16,934,736.3	-
САНГИЙН ҮР ДҮН			
Тэтгээрийн даатгалын сангийн	- 14,824,255.8	- 14,824,255.8	-
Тэтгэмжийн даатгалын сангийн	- 311,585.1	- 311,585.1	-
ҮОМШӨ-ний даатгалын сангийн	742,532.6	742,532.6	-
Зрүүл мэндийн даатгалын сангийн	2,657,544.1	2,657,544.1	-
Ажилгүйдлийн даатгалын сангийн	116,116.1	116,116.1	-

Нягтлан бодогч

Баталгаажуулсан



Н.Норгимбадам

Б.Эрдэнэцэцэг

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Аудитлагдаагүй үлдэгдэл	Аудитлагдсан үлдэгдэл	Өөрчлөлт
МОНГО БА ҮҮҮНТЭЙ АДИЛГАХ ХӨРӨНГӨ	411.9	411.9	0.0
Төсвийн харилцах	411.9	411.9	0.0
АВЛАГА	2265.4	2265.4	0.0
БАРАА МАТЕРИАЛ	21758.5	21758.5	0.0
Хангамжийн материал	10197.1	10197.1	0.0
Хүнрэй материал			0.0
Бусад	11561.4	11561.4	0.0
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	24435.8	24435.8	0.0
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	87110.4	87110.4	0.0
Биет хөрөнгө	87110.4	87110.4	0.0
Барилга, байгууламж	29030.0	29030.0	0.0
Хуримтлагдсан ачаадал	9411.9	9411.9	0.0
Авто-тээврийн хэрэгсэл	18000.0	18000.0	0.0
Хуримтлагдсан ачаадал	15250.0	15250.0	0.0
Машины, тоног төхөөрөмж	69051.7	69051.7	0.0
Хуримтлагдсан ачаадал	25630.4	25630.4	0.0
Төвлөлт, аж ахуйн эд хөшөө	73343.5	73343.5	0.0
Хуримтлагдсан ачаадал	52022.0	52022.0	0.0
Номын фонд	0.0	0.0	0.0
Биет бус хөрөнгө	0.0	0.0	0.0
Программа хангамж	7504.8	7504.8	0.0
Хуримтлагдсан ачаадал	7504.8	7504.8	0.0
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	87110.4	87110.4	0.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	111546.2	111546.2	0.0
ӨР ТӨЛБӨР	13345.6	13345.6	0.0
Бусад өглөг	13345.6	13345.6	0.0
ЭЗНИЙ ӨМЧ	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь орлого	231261.2	231261.2	0.0
Хуримтлагдсан үр дүн	-158638.1	-158638.1	0.0
Өмнөх үеийн үр дүн	-139450.5	-139450.5	0.0
Тайлант үеийн үр дүн	-19187.6	-19187.6	0.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	25577.5	25577.5	0.0
ЭЗНИЙ ӨМЧИЙН ДҮН	98200.6	98200.6	0.0
ӨР ТӨЛБӨР, ЭЗНИЙ ӨМЧИЙН ДҮН	111546.2	111546.2	0.0
ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН			

2013 оны 12 сарын 31-ний байдлаар

ҮЗҮҮЛЭЛТ	Аудитлагдаагүй дүн	Аудитлагдсан дүн	Өөрчлөлт
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО			
ТАТААС БА САНХҮҮЖЛИЙН ОРЛОГО	545107.8	561360.8	-16253.0
Нийгмийн даатгалаас			0.0
Улсын төсвөөс	533507.8	533507.8	0.0
Хөрөнгийн орлого			-16253.0
Нэмэлт санхүүжилт	11600.0	11600.0	0.0
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	19487.8	3234.8	16253.0
Төсөвт байгууллагуудын талбөртөл үйлчилгээний орлого	19487.8	1214.8	18273.0
Үндсэн үйл ажиллагааны орлого			0.0
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	19487.8	1214.8	18273.0
Үнэ талбэргүй өссөн орлого		2020.0	-2020.0
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	564595.6	564595.6	0.0
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ			
АЖИЛЛАГЧИДАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	452372.1	452372.1	0.0
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	407542.4	407542.4	0.0
Цалин	407542.4	407542.4	0.0
Нийгмийн даатгал	44829.7	44829.7	0.0
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	44829.7	44829.7	0.0
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	130091.6	130091.6	0.0
Тогтмол зардал	9593.1	9593.1	0.0
Үйл ажиллагааны зардал	98249.0	98249.0	0.0
Мэдээлэл сурталчилгаа			0.0
Элэг дүлийн зардал			0.0
Нэг удаагийн тэтгэмж	11673.9	11673.9	0.0
Төвлөрүүлэх шилжүүлэг	10575.6	10575.6	0.0
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	582463.7	582463.7	0.0
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)-(IV)	-17868.1	-17868.1	0.0
Үндсэн хөрөнгө ахсананы гарз	1319.4	1319.4	0.0
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)-(IV)	-19187.5	-19187.5	0.0

Нягтлан бодогч
Баталгаажуулсан

Ц.Лхамсүрэн
Аудитор Б.Эрдэнэцэцэг
Шинжээч Н.Буянтогтох

